

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.020

| | |
|--|-----------------------------|
| Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт | MNS 5914 : 2008 |
| Environment. Land reclamation. Terms and definitions | MNS 17.5.1.13-80 -ийн оронд |

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2009 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэ стандартын зорилго нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх асуудалтай холбогдолтой нэр томьёо, тодорхойлолтыг тогтооход оршино.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэв. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

- ГОСТ 17.5.1.01-83, Байгаль хамгаалал, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо ба тодорхойлолт;
- MNS 3473:1983, Байгаль хамгаалал. газар, газар ашиглалт, нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 0017-0-0-06:1979, Байгаль орчныг хамгаалах стандартын систем. Үндсэн дүрэм;
- ASTM D 653-07, Standard terminology Relating to soil, rock and Contained Fluids;
- Soil Classification - 1926 Subpart P App A - The Unified Soils Classification System; The U.S. Department of Agriculture (USDA);
- MNS ISO 14050:2003, Байгаль орчны менежмент (удирдлага)- Тайлбар толь;
- Glossary to Terms in Soil Science. 1972. Canada Department of Agriculture Publication 1459.

3 Ерөнхий зүйл

3.1

ашигт малтмал

геологийн хувьсгал, өөрчлөлтийн үр дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсэж бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдэс бодисын хуримтлал

3.2

ашигт малтмал ашиглах

газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа

3.3

ашигт малтмал хайх

эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийх

3.4

ашигт малтмал эрэх

ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийж байгаа геологийн судалгааны ажил

3.6

ашигт малтмалын орд

геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлал

3.7

ашигт малтмалын үндсэн орд

геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд бүрэлдэн тогтож анхлан үүссэн чулуулагтайгаа нэг орон зайд байрлаж байгаа эрдсийн хуримтлал

3.8

ашигт малтмалын шороон орд

анхлан үүссэн чулуулаг, орон зайнаасаа өгөршил, элэгдэл, механик үйл явцын дүнд сарнин салж, дахин хуримтлагдаж улмаар үе, давхарга байдалтай байгаа эрдсийн хуримтлал

3.7

ашигт малтмалын үүсмэл орд

олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаягдал хэлбэрээр газрын гадаргуу болон уулын малталт дотор үүссэн тоо хэмжээ, чанарын хувьд үйлдвэрлэлийн аргаар ашиглах боломжтой эрдсийн хуримтлал

3.8

ашигт малтмалын орд илэрцийн урьдчилсан үнэлгээ

хайгуулын ажлаар илрүүлсэн эрдэс баялаг дээр тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн боломжийн талаар тойм судалгаа, хязгаарлагдмал хэмжээний туршилт, шаардлагатай зарим инженерийн болон эдийн засгийн тооцооны үр дүнг нэгтгэсэн баримт бичиг

3.9

ашигт малтмалын орд илэрцийн техник эдийн засгийн үнэлгээ

ашигт малтмалын ордын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зорилгоор хайгуулын ажлаар тогтоосон эрдэс баялаг дээр тулгуурлан уул уурхайн (ашигт

малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төсөл хэрэгжүүлэх хувилбаруудын техник, технологийн боломж, эдийн засгийн үр ашгийг тооцсон баримт бичиг

3.10

ашигт малтмалын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)

улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн (ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах) төслийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник, технологийн сонголт, тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн баримт бичиг

3.11

ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төсөл

уул уурхайн үйлдвэр, түүний хэсэг цехийг барьж байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, тооцоо, зураг, макет, төсөв, тайлбар бичиг бусад материалаас бүрдэх техникийн иж бүрэн баримт бичиг

3.12

ашиглалтын тусгай зөвшөөрөл

хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичиг

3.13

байгаль орчин

агаар, ус, газар, байгалийн нөөц, ургамал, амьтны аймаг, хүн болон тэдгээрийн хоорондын харилцааг оролцуулагч тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хүрээлэл

ТАЙЛБАР: Хүрээлэл гэдэгт тухайн байгууллагаас эхлэн дэлхий нийтийн тогтолцоог ойлгоно.

3.14

байгаль орчны асуудал

байгаль орчинтой харилцан үйлчилж байгаа, тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба үйлчилгээний бүрдэл хэсэг

ТАЙЛБАР. Байгаль орчны тулгамдсан асуудал нь байгаль орчинд ноцтойгоор нөлөөлж байгаа эсвэл нөлөөлж болзошгүй байгаль орчны асуудал юм.

3.15

байгаль орчны аудит

байгаль орчны талаарх тухайлсан үйл ажиллагаа, арга хэмжээ, нөхцөл, удирдлагын тогтолцоо, эсвэл тэдгээрийн тухай мэдээлэл аудитын шалгуурт тохирч байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор аудитын баримтыг бодитойгоор олж дүгнэн, үр дүнг үйлчлүүлэгчдэд мэдээлэх тогтолцоотой, баримтжуулсан шалгаж батлах үйл явц

3.16

байгаль орчны гүйцэтгэл

(Удирдлагын тогтолцоо) байгаль орчны бодлого, зорилго ба зорилтод үндэслэсэн бөгөөд тухайн байгууллагаас байгаль орчны асуудлаа хянаж удирдахад холбогдолтой байгаль орчны удирдлагын тогтолцооны бодит үр дүн

3.17

байгаль орчны гүйцэтгэлийн заагч

байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн тухай мэдээллээр хангахуйц онцлог илэрхийлэл

3.18

байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ

заагчийг сонгох, өгөгдлийг цуглуулж, шинжлэх, гүйцэтгэлийн эко шалгууртай холбоо бүхий мэдээллийг үнэлж дүгнэх, тайлагнах, харилцан мэдээлэх, график хуваариар дүн шинжилгээ хийх, үйл явцыг сайжруулахаар байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг үнэлэх талаар удирдлагын шийдвэрлэх ажиллагаа

3.19

байгаль орчны нөхцөл байдлын заагч

орон нутгийн, бүс нутгийн, үндэсний, дэлхийн хэмжээний байгаль орчны тухай мэдээллээр хангах онцлог илэрхийлэл

ТАЙЛБАР: “Бүс нутаг” гэдэг нь байгууллагын анхаарлаа хандуулахаар сонгосон байгаль орчны нөхцөл байдлын хэмжээнээс хамаарч улс, муж эсвэл нэг улсын хэсэг муж, эсвэл нэг тивийн хэсэг улс байж болно.

3.20

газар

газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхарга

3.21

газар ашиглах

тухайн газрыг захиран зарцуулах эрхгүйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд болон гэрээнд заасны дагуу газрын аль нэг шинж чанарыг ашиглах тодорхой үйл ажиллагаа

3.22

газрыг чөлөөлөх

тухайн газрыг эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх, газрыг засаж тохижуулах зэргээр хууль болон газар эзэмших, ашиглах гэрээнд зааснаар газрыг өмчлөгчид нь эргүүлэн өгөхөд саадгүй болгох

3.23

тусгай зөвшөөрөл эзэмшигч

ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх авсан, эсхүл түүнийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээд

3.24

тусгай хэрэгцээний газар

эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газар

3.25

уурхайн талбай

ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай

3.26

уурхайн эдэлбэр

уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтцын хэсэг

3.27

хөрс

газрын гадаргын дээд хэсэгт орших үржил шимт үе давхарга бөгөөд хурдас чулуулаг, уур амьсгал, ургамал, амьтан, газрын гадарга, цаг хугацааны хүчин зүйлүүдийн нарийн төвөгтэй үйлчлэлийн үр дүнд бий болсон зүйл

3.28

дунд зэрэг угаагдсан хөрс

А давхарга нь хагас буюу бүрэн угаагдсан хөрс

3.29

сул угаагдсан хөрс

А давхарга нь хагасаас илүүгүй угаагдсан хөрс

3.30

хүчиллэг хөрс

pH нь 7,0-оос доошгүй байх хөрс

A¹ давхарга нь бүрэн угаагдсан, B² давхаргын шилжилтийн зааг үе зарим хэсгээрээ угаагдсан хөрс

3.31

хүчтэй угаагдсан хөрс

pH нь 7,0-оос ихгүй байх хөрс

3.32

шүлтлэг хөрс

ТАЙЛБАР: 1. Хөрсний шимт үе (А)

2. Шимт үеийн дор орших шимэрхэг үе

3.33

хөрсжүүлэлт

үржил шим багатай газрыг сайжруулах зорилгоор үржил шимт үе давхарга эсвэл үржил шимийн чадавх боломж бүхий чулуулгийг хуулах, зөөх, тараан асгахад чиглэсэн цогцолбор ажиллагаа

3.34

хөрсний ангилал

хөрсийг морфологи, хими, ус-физик, биологийн зэрэг аль нэг шинж чанараар нь харьцуулан үнэлж ангилах үйлдэл

3.35

хөрсний доройтол

үржил шимт чанараа алдах үйл явц

ТАЙЛБАР: Хөрсний доройтол нь эвдрэл, бохирдол гэсэн 2 үндсэн чиглэлээр явагдана.

3.36

хайгуулын талбай

хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгосон талбай

3.37

хайгуулын тусгай зөвшөөрөл

хуулийн дагуу ашигт малтмал эрх, хайх эрх олгосон баримт бичиг

4 Уурхайн технологи

4.1

агуулагч чулуулаг

хүдрийн биет судал буюу ашигт малтмал агуулсан ямар нэгэн геологийн биетийг агуулж тогтсон чулуулаг

4.2

ашигт малтмалыг бөөнөөр нь олборлох

ашигт малтмалыг ямар нэгэн шинж чанар үзүүлэлтээр нь ялгаварлахгүйгээр олборлох

4.3

ашигт малтмалыг ялгаварлан олборлох

ашигт малтмалыг агуулга, кондици, баяжих, коксжих чанар зэрэг шинж чанараар нь ангилан олборлох

4.4

далд аргаар ашиглах

ашигт малтмалын ордын нээлт, үндсэн болон бэлтгэл ажил, олборлолт нь газрын гүнд явдаг ашиглалтын арга

4.5

далангийн дагуух шуудуу

далан байгуулахаар чулуулгийг гаргаж авахад үүссэн шуудуу

4.6

дэл

шугаман барилга байгууламж барих үед ухсан шуудуунаас гарсан чулуулгийн овоолго

4.7

ил аргаар ашиглах

хөрс хуулалт олборлолтын ажил нь газрын гадаргууд ил орон зайд явагддаг, ашигт малтмалын ордыг ашиглах арга

4.8

ил аргаар нийтэд нь хуулах

хамт орших хөрсний төрөл бүрийн чулуулгийг ялгаварлахгүйгээр бөөнд нь хуулж ил аргаар ашиглах

4.9

ил аргаар ялгаварлан хуулах

хамт орших хөрсний төрөл бүрийн чулуулгийг ялгаварлан хуулж ил аргаар ашиглах

4.10

ил уурхайн ажлын бус хажуу

ил уурхайн хүрээний шугам дээр байрласан, цаашид уулын ажил өрнөхгүй, байнгын болон туслах зам, шугам сүлжээ байрлуулж болох нуралт, гулсалт явагдахгүй байх тогтвортой байдлын нөхцөлийг хангасан уурхайн хана

4.11

ил уурхайн ажлын бус хажуугийн өнцөг

ил уурхайн ажлын бус хажуугийн доголлуудын дээд эсвэл доод ирмэгийг холбож татсан налуу шугам, хэвтээ хавтгайтай үүсгэх өнцөг

4.12

ил уурхайн ухаш

хатуу ашигт малтмалын ордыг ил аргаар дотоод, гадаад овоолготойгоор ашиглах үед уулын малталтаар үүссэн орон зай

4.13

ил уурхайн дэнжилсэн ухаш

газрын доорх ашигт малтмалыг олборлохоор хэд хэдэн догол, дэнж, үүсгэсэн ухаш

4.14

ил уурхайн үлдэгдэл ухаш

дотоод овоолгын налуу ба уурхайн ханаар хязгаарласан орон зай

4.15

овоолго

сонгож бэлдсэн талбай дахь хөрсний болон агуулагч чулуулаг, кондицийн бус ашигт малтмал, үйлдвэрийн хоргүй хаягдлын хиймэл хэсэг

4.16

гадаад овоолго

ил уурхайн хүрээний гадна байрласан сийрэгжсэн чулуулгийн овоолго

4.17

далд уурхайн овоолго

ашигт малтмалын ордыг далд аргаар ашиглах үед гарсан хоосон чулуулгийн овоолго

4.18

дотоод овоолго

ил уурхайн ухаш дотор байрласан сийрэгжсэн чулуулгийн овоолго

4.19

овоолго байгуулалт

ашигт малтмалын ордыг ил ба далд аргаар ашиглах үед зориуд сонгож, бэлдсэн талбай болон ил уурхайн хоосон орон зайд овоолго үүсгэх үйл явц

4.20

овоолгыг өөрчлөх

цаашид эзэмших боломжтой нөхцөлийг хангах, өөрөө шаталтаас урьдчилан

сэргийлэх, гарсан галыг унтраах зорилгоор овоолгын хэлбэрийг өөрчлөх

4.21

овоолгын зураглал

овоолгын чулуулгийн бүрдэл, тархалт болон чулуулгийн шаардлагатай зарим шинж чанар, гадаргын үүсэл, гадарга зүйн хэмжээсийг тодорхойлж, зураглал хийх

4.22

овоолгын хөрс

утгах, тээвэрлэх, овоолох үед ямар нэгэн хэмжээгээр холилдсон, овоолгыг бүрдүүлэгч сийрэгжсэн чулуулаг

4.23

траншей (гуу)

ихэвчлэн ил уурхайг нээх болон геологи хайгуулын зориулалтаар малтдаг.. Хөндлөн огтлол нь трапец хэлбэртэй, уртыг нь өргөн ба гүнтэй жишихэд мэдэгдхүйц их ил малталт

4.24

хөрсний чулуулаг

ашигт малтмалын оршдосыг хучиж тогтсон болон түүнтэй хамт орших ил аргаар ашиглахад зайлшгүй хуулагдах чулуулаг

4.25

хөрсний чулуулаг хамт орших

харилцан адилгүй шинж чанартай төрөл бүрийн чулуулаг хоорондоо холилдолгүйгээр зэрэгцэн буюу давхцан орших

4.26

чулуулгийг ялгаварлан овоолох

хөрсний чулуулгийг биологийн нөхөн сэргээлтэд тохирох шинжийг харгалзан тусад нь, эсвэл тодорхой дарааллаар ялгаварлан байршуулах

4.27

чулуулгийг бөөнөөр овоолох

хөрсний чулуулгийг агрохимийн болон физик, механикийн шинж чанараар нь ялгахгүйгээр овоолох

5 Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх

5.1

нөхөн сэргээлт

эвдэрсэн газрын аж ахуйн ач холбогдол болон газрын үржил шимийг сэргээх, хүрээлэн байгаа орчны нөхцөлийг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэгдсэн цогцолбор ажиллагаа

5.2

нөхөн сэргээлтийн үе давхарга

биологийн нөхөн сэргээлтэд тохиромжтой техникийн нөхөн сэргээлтийн шатанд зориуд тавигдсан хөрсний дээд үе

5.3

нөхөн сэргээлтийн үе шат

газрыг нөхөн сэргээхэд чиглэгдсэн дэс дараатай гүйцэтгэж буй цогц ажил

ТАЙЛБАР: эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн гэсэн хоёр үндсэн үе шатаар авч үзнэ.

5.4

нөхөн сэргээлтийн хаалтын төсөл

уулын үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, хөрс чулуулгийн биологийн нөхөн сэргээлтэд тохирох шинжийн ангилал, инженер геологийн судалгаа зэрэгт үндэслэн холбогдох стандартын дагуу хийсэн техникийн нөхөн сэргээлтийн техник, технологийн тооцоо, зураг, биологийн буюу хоёр дахь шатны нөхөн сэргээлтийн туршилт, шинжилгээний үр дүн, тооцоо, зардлын төсөв зэргийг иж бүрэн тусгасан баримт бичиг

5.5

нөхөн сэргээсэн газар

нөхөн сэргээлтийн үр дүнд аж ахуйн үнэ цэн, үржил шим нь сэргээгдсэн, байгаль орчны нөхцөл нь сайжирсан газар

5.6

нөхөн сэргээх газар

хүний үйл ажиллагаагаар эвдэрсэн нөхөн сэргээвэл зохих газар

5.7

нөхөн сэргээх чиглэл

эвдэрсэн газрыг аж ахуйн тодорхой чиглэлээр эргэлтэд оруулах чиглэл

1-Р ТАЙЛБАР: ил уурхайн нөхөн сэргээх үндсэн чиглэл:

ХАА, ойн аж ахуй, усны аж ахуй, амралтын бүс, барилга байгууламж барих

2-Р ТАЙЛБАР: Далд уурхайн нөхөн сэргээлтийн үндсэн чиглэл:

Газрын доорх агуулах, эмчилгээний камер, сургалтын бааз байгуулах, битүүмжлэн хаах

5.8

уулын үйлдвэрлэлийн ландшафт

гарал үүсэл, бүтэц нь уулын олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой үүсмэл ландшафт

5.9

технологийн үүсмэл (техногенез)

үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөгөөр байгалийн цогцолборын өөрчлөгдөх төрх

5.10

үүсмэл гадарга

үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөгөөр газрын гадаргын унаган төрх алдагдаж, бий болсон гадарга

5.11

эвдэрсэн газрын бүртгэл

эвдэрсэн газрын байршлыг газар дээр нь тодорхойлж, зураглал гарган хэмжээ,

чанар байдлыг тогтоох

5.12

экосистем

хүрээлэн буй орчин түүний нэгж хэсгүүдийн амьд бус хүчин зүйлүүдтэй нь нэгдмэл байдлаар авч үзэх систем

6 Техникийн нөхөн сэргээлт

6.1

газар тэгшлэх ажил

эвдэрсэн газрын гадаргыг тэгшлэх, овоолго ба ил уурхайн хажуугийн ханыг хэвгийжүүлэх ажил

6.2

газрыг бүрэн тэгшлэх

газар шорооны бага зэргийн ажлын үед гадаргыг бүрэн тэгшилж, бичил засвар хийх

6.3

газрыг ерөнхийд нь тэгшлэх

газар шорооны үндсэн ажил гүйцэтгэхийн зэрэгцээ гадаргын түвшинг жигд болгох

6.4

газрыг тууш тэгшлэх

эвдрэлд орсон газрыг хөдөө аж ахуйн болон механикжуулсан ойжуулалтын зориулалтаар зөвшөөрөх налууугай хэвгийжүүлэн тэгшлэх

6.5

газрыг хэсэгчилж тэгшлэх

эвдэрсэн газрыг тодорхой зориулалтын дагуу хэсэгчлэн тэгшлэх

6.6

налуу гадаргыг бэхжүүлэх

техник хэрэгсэл ашиглах болон ургамалжуулах арга замаар налуу газрын эвдрэлийг багасгаж, тогтворжуулах

6.7

налуу гадаргын хэлбэршүүлэлт

овоолго болон ил уурхайн хажуугийн өнцгийг бууруулах газар шорооны ажил

6.8

нөхөн сэргээсэн газрын засвар

овоолгын чулуулгийн нягтрал, ус, дулааны өөрчлөлт, салхины нөлөөллөөр үүссэн эвдрэлийг тэгшлэх, гидротехникийн байгууламж, замын гэмтлийг засварлах ажил

6.9

техникийн нөхөн сэргээлт

эвдэрсэн газрыг нийтийн хэрэгцээнд тодорхой зориулалтаар ашиглахад бэлтгэх нөхөн сэргээлтийн анхан шатны ажил

6.10

халхлах давхарга

биологийн нөхөн сэргээлтэд тохиромжгүй чулуулгийн үе дээр элс, хайрга, дайрга, саармагжуулагч асгаж түүний ус чийг огшуулах (капляр) сүвийг хаах зориулалтаар үүсгэсэн давхарга

6.11

хучаас үе

нөхөн сэргээгдэж байгаа бусад хэсэгт болон овоолгын гадаргад ялгаварлан хуулж тараасан үржил шимт хөрс болон үржил шимийн чадавхтай чулуулгийн үе

6.12

суулт

газрын дор олборлолт явуулах юмуу хураасан овоолго нягтарснаас газрын гадаргын хагаралтгүйгээр дагуудаа доош суусан хэсэг

6.13

хотойц

далд аргаар ашиглалт явуулсны дараа чулуулгийн шилжилтийн нөлөөгөөр гадаргад үүссэн хонхор

6.14

цөмөрхий

ашигт малтмалыг олборлох үед газрын гадарга доош сууснаас гадаргын эвдрэлтэй үүссэн хонхор

7 Биологийн нөхөн сэргээлт

7.1

биологийн нөхөн сэргээлт

техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт хөрсний үржил шимийг сэргээх, ургамалжуулах зорилготой хийгдэх агротехник, фитомелиорацийн ажил

7.2

биологийн нөхөн сэргээлт хийх чулуулгийн ангилал

хөрсний болон агуулагч чулуулгийн биологийн нөхөн сэргээлтэд тохирох шинжээр нь төрөлжүүлэн ангилах

7.3

бут сөөг

ишнийхээ угаас эхлэн олон салаа иш үүсгэдэг, тодорхой нэг гол ишгүй, 5 м хүртэл өндөр ургадаг, олон наст ургамал /бүх зүйлийн бургас, гүйлс, бүйлс, долоогоно, ерөл, хар улаан үхэр нүд, хад, тошлой гэх мэт/

7.4

олон наст ургамал

гол иш нь моджихгүй, өвслөг, газар дээрх хэсэг нь намар хагдардаг, 2 ба түүнээс дээш жил амьдардаг, олон жил нөхөн төлжин ургах чадвартай ургамал

7.5

буурцагт ургамал

навч, иш, буурцган дахь үрд уургаар баялаг, үндэс дээрх жижиг булцуунд нь үржигч бактери агаарын азотыг шингээн хуримтлуулж, хөрсний үржил шимийг баяжуулдаг онцлог бүхий; үндэсний хүзүүвчнээс сэргэн ургаж, ургамлын нөмрөг

үүсгэгч бүлэг ургамал /царгас, хүцэнгэ, сэвэг зарам, хошоонгор гэх мэт/

7.6

үет ургамал

үет иш, мөчир, түрүү болон залаа баг цэцэг, шугаман урт навчтай, тарьсан жил болон цаашдын жилүүдийн намар иш, навч, түрүү нь хагдравч дараачийн хавартаа үндэслэг иш, үндэсний хүзүүвчний нахиануудаас сэргэн ургаж, эзлэх хүрээгээ тэлж, 2-3 замаар газрын гадаргууг бүрхдэг биологийн онцлог бүхий бүлэг ургамал /согоовор, өлөнгө, ерхөг, хялгана, биелэг өв гэх мэт/

7.7

мод

нэг гол иштэй, түүнээсээ салбарласан олон салаа мөчир бүхий 5 м-ээс дээш өндөр ургадаг, хөрсний гүнд нэвтэрдэг, хүчирхэг үндэсний системтэй, олон наст том ургамал /улиас, улиангар, шинэс, нарс, гацуур гэх мэт/

7.8

ургамалжуулах

элэгдэж эвдэрсэн газарт боловсруулалт хийж, олон наст ургамал тарьж, ургамлан бүрхүүл буй болгох үйл ажиллагаа

7.9

ургамлын үр

нарийн зохион байгуулалт бүхий дээд ургамал /нүцгэн ба далд үртэй/-ын хөгжлийн явцад үр тогтолтын үр дүнд үр хөврөл бүхий үржлийн тусгай эрхтэн

7.10

үр

тарихад зориулан бэлтгэсэн үрийн материал

ТАЙЛБАР: Үрд үр өөрөө, үр жимс, нийлмэл үр жимс, түрүү, булцуу болон бусад зүйл

7.11

үржил шимийн тохиромж муутай чулуулаг

бутлагдсан хэмжээ, химийн шинж чанараараа ургамлын өсөлт хөгжилтөд саад учруулдаг чулуулаг. Энэ төрлийн чулуулагт халхлах үе тавих болон язгуур сайжруулалтын аргыг хэрэглэнэ.

7.12

үржил шимийн чадавхитай чулуулаг

ургамлын өсөлтөд тохиромжтой физик, химийн болон агро-химийн зарим шинж чанарыг агуулсан чулуулаг

7.13

үржил шимт хөрс

ургамлын өсөлтөд шаардагдах физик, химийн болон агро химийн зохистой шинжүүдийг агуулсан хөрсний давхаргын ялзмагтай дээд хэсэг

7.14

хөрсний үржил шим

ургамлыг шаардлагатай шим тэжээлийн бодис, усаар хангах, үндэсний системийг агаар болон дулааны тохиромжтой нөхцөлд байлгаснаар ургамлын ургах, ургац

өгөх нөхцөлийг бүрдүүлэх чадвар

7.15

чулуулгийг сайжруулах

нөхөн сэргээх газрын гадаргыг үүсгэж буй чулуулаг болон тэдгээрийн холимгийн физик, химийн шинж чанарыг сайжруулахад чиглэсэн ажил

ТАЙЛБАР: Сайжруулалтын энэ ажилд шаваржуулах, элсжүүлэх, шохойжуулах, угаах болон хөрсний орчныг өөрчлөхөд чиглэгдсэн бусад арга хэмжээ

7.16

биологийн сайжруулалт

агротехникийн болон усжуулалтын аргуудыг хэрэглэх замаар эвдэрсэн газрын үржил шим, хөдөө аж ахуй болон ойн ургамлын ургацыг эрчимтэй нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц ажил

7.17

сайжруулах хугацаа

үндсэн ба биологийн сайжруулалт хэрэглэх замаар нөхөн сэргээх газрын шимт чанарыг дээшлүүлэхэд шаардагдах хугацаа

ТАЙЛБАР: нөхөн сэргээж ургамалжуулсан уурхайн эдэлбэрийн тухайн хэсгийг хайс тороор хашиж 5-аас 7 хүртэлх жилийн дотор байгалийн аясаар сэргээх боломжийг бүрдүүлэх нормативыг тухайн бүс нутаг бүрт туршилтаар тогтооно.

7.18

язгуур сайжруулалт

ургамлын өсөлтөд саад учруулдаг овоолгын өнгөн хэсэгт орших чулуулгийн шинж чанарыг үндсээр нь өөрчлөн сайжруулах, цаашид газрын үржил шимийг дээшлүүлж, ургацыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил

7.19

шим бордоо

таримал ургамлын шим тэжээлээр хангах зорилгоор тусгайлан ялзруулж бэлтгэсэн ургамал, амьтан, бичил биетээс гаралтай шим бодис

ТАЙЛБАР: мал, амьтны бууц, ногоон бордуурын ургамал, сангас, био ялзмаг, бактерийн бордоо гэх.мэт

7.20

ялзмаг

газрын өнгөн хөрсний А давхаргад хуримтлагдаж, ургамлын үндсээр дамжуулан эд эрхтнийг нь шим тэжээлээр хангагч амьд бие махбодиос гаралтай шим, эрдэс бордоо

ТӨГСӨВ.